- 34.2. ТШЗ-ны 34.1-т заасан нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх тооцохгүй ба энэ нь тухайн тендерт оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болохгүй.
- 35. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох**
- 35.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход дараах дарааллыг баримтална:
- 35.1.1. ТШЗ-ны 20 дугаар зүйлд зааснаар санал болгосон тендерийн үнийг тогтоох;

- 35.1.2. ТШЗ-ны 33.1-д заасны дагуу тендерийн үнэд хийсэн арифметик алдааг залруулах;
- 35.1.3. ТШЗ-ны 20.4-т заасны дагуу санал болгосон үнийн хөнгөлөлт тооцох;
- 35.1.4. ТШЗ-ны 35.1.1-35.1.3-т заасан үнийг шаардлагатай бол ТШЗ-ны 32 дугаар зүйлд зааснаар нэг валютад хөрвүүлэх;
- 35.1.5. ТШЗ-ны 34 дүгээр зүйлд зааснаар давуу эрх олгох;
- 35.1.6. ТШЗ-ны 31.2-т заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж тооцох.
- 35.2. Тендерийн үнийг залруулсан, үнийн хөнгөлөлт тооцсон, нэг валютад хөрвүүлсний дараах үнэ төсөвт өртгөөс 5-аас дээш хувиар хэтэрсэн бол хуулийн 30.1.3-ыг үндэслэн уг тендерээс татгалзана.
- 35.3. ТШЗ-ны 1.2-т заасны дагуу хоёр ба түүнээс дээш багцтай тендер шалгаруулалтад хэд хэдэн багцад хамтад нь хамгийн бага харьцуулах үнэ санал болгосон тендерийг тодорхойлох, түүнд санал болгосон үнийн хөнгөлөлтийг тооцохдоо дараах аргачлалыг баримтална:
- 35.3.1. багц тус бүрийн хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг ТШЗ-ны 35.1-д заасны дагуу сонгох;
- 35.3.2. хоёр ба түүнээс дээш багцад гэрээ байгуулах эрх авсан тохиолдолд үнийн хөнгөлөлт үзүүлэхээр санал болгосон тендерийн үнээс уг үнийн хөнгөлөлтийг тендер илгээх маягтад тодорхойлсон аргачлалын дагуу тооцсоны дараа шаардлагатай бол түүний харьцуулах үнийг дахин тодорхойлно. Ийнхүү тодорхойлохдоо хоёр ба түүнээс дээш багцад хамгийн бага харьцуулах үнэтэй тендер ирүүлсэн этгээд нь ТШЗ-ны 37.2-т зааснаар дахин магадлахад шаардлага хангаж байхыг шаардана;
- 35.3.3. дээрх үнэлгээг хийсний дараа тендерийн харьцуулах үнэд үндэслэн захиалагч гэрээ байгуулах эрхийг нэг багцад, хэд хэдэн багцад, эсхүл бүх багцад олгох хувилбаруудыг тооцож, гэрээний үнийн нийлбэр нь хамгийн бага байх хувилбарыг сонгох.
- 35.4. ТШЗ-ны 16.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг хянан үзэж, үнэлнэ.



- 35.5. ТШЗ-ны 35.4-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.
- 36. Тендерийг харьцуулах, хэлэлцээ хийх**
- 36.1. Захиалагч “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийг сонгохдоо хуулийн 28.7.3-т заасны дагуу тендерүүдийг эрэмбэлж, хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг сонгоно.
- 36.2. Хуульд заасан үндэслэлээр тендерт оролцогчтой хэлэлцээ хийх тохиолдолд хэлэлцээний үр дүнд түүний тендерийн захиалагчийн тавьсан шаардлага, шалгуур үзүүлэлт, барааны тоо хэмжээнд үл хамаарах хэсэгт өөрчлөлт оруулахыг зөвшөөрнө.
- 37. Тендерт оролцогчийн чадавхыг дахин магадлах**
- 37.1. Захиалагч хэд хэдэн багцад “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн тендерт оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг дахин магадалж болно.
- 37.2. ТШЗ-ны 37.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 18 дугаар зүйлд заасан санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.
- 37.3. Хэрэв тендерт оролцогчийг хэд хэдэн багцад гэрээ байгуулахад шаардлага хангахгүй гэж магадалсан бол түүний гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхын шаардлагыг хангах нэг, эсхүл түүнээс дээш багцад гэрээ байгуулах эрх олгоно.
- 37.4. “Хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийн гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхыг дахин магадалж шаардлага хангахгүй гэж үзвэл уг тендерээс татгалзана. Энэ тохиолдолд удаах хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер гэж үзэж, оролцогчийн чадавхыг мөн адил зарчмаар магадална.

## **Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ**

- 38. Мэдэгдэл хүргүүлэх**
- 38.1. Захиалагч дараах мэдэгдлийн аль тохирохыг тендерт оролцогч тус бүрд бичгээр хүргүүлж, тухайн өдөрт багтаан цахим системд байршуулна:
- 38.1.1. “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгох ;
- 38.1.2. ТШЗ-ны 38.1.1-т зааснаас бусад шаардлага хангасан тендер ирүүлсэн оролцогчид шалгараагүй тухай мэдэгдэх;
- 38.1.3. ТШЗ-ны 30.7, 35.2-т заасан тендерээс татгалзах.

- 38.2. Захиалагч гэрээ байгуулах эрх олгосон бол энэ тухай шийдвэр, мэдэгдэл болон “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийг холбогдох журмын дагуу ил болгох тухай ТШЗ-ны 38.1.2, 38.1.3-т заасан мэдэгдэлд дурдана.
- 38.3. Захиалагч бүх тендерээс татгалзсан бол хуулийн 30.4-т заасан дахин нээлттэй, хязгаарлагдмал тендер шалгаруулалт явуулах, эсхүл гэрээ шууд байгуулах тухай шийдвэрийг ТШЗ-ны 38.1.3-т заасан мэдэгдэлд дурдана.<sup>1</sup>
- 39. Гэрээ байгуулах эрх олгох**
- 39.1. Захиалагч “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрхийг ТШЗ-ны 38.1.1-д заасан мэдэгдлээр олгоно. Хэрэв “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн үнийг залруулсан, үнийн хөнгөлөлт тооцсон, нэг валютад хөрвүүлсэн бол уг үнийг гэрээний үнээр тогтоож, гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заана.
- 39.2. Дараах тохиолдолд хуулийн 20.7.2-т заасан нөхцөл үүссэн гэж үзэж тендерийн баталгааг улсын орлого болгоно:
- 39.2.1. гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд дурдсан гэрээний үнийг хүлээн зөвшөөрөөгүй;
- 39.2.2. ТШЗ-ны 40 дүгээр зүйлд заасны дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй (хэрэв гүйцэтгэлийн баталгаа шаардсан бол);
- 39.2.3. ТШЗ-ны 41 дүгээр зүйлд заасны дагуу гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулаагүй.
- 39.3. ТШЗ-ны 39.2-т заасан нөхцөл байдал үүсвэл удаах хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер гэж үзэж гэрээ байгуулах эрх олгоно.
- 40. Гүйцэтгэлийн баталгаа**
- 40.1. ТӨХ-д заасан бол шалгарсан тендерт оролцогч нь тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг ТШЗ-ны 8.5-д заасан гэрээний нөхцөлийн хавсралт маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.
- 40.2. Гүйцэтгэлийн баталгаа нь ТШЗ-ны 23.3-т заасан хэлбэрээр байж болох ба гадаадын этгээдээс гаргуулах бол ТШЗ-ны 23.4-т заасан шаардлагыг хангасан байна.
- 40.3. Захиалагчийн хүлээн авсан, шаардлага хангасан гүйцэтгэлийн баталгаа нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 41.1. Захиалагч ТШЗ-ны 8.5-д заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын

<sup>1</sup> Гэрээ шууд байгуулах аргаар тендер шалгаруулалт зохион байгуулах үед энэ заалт хамаарахгүй.

**41. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах**

дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, шалгарсан тендерт оролцогчид хүргүүлнэ.

41.2. Шалгарсан тендерт оролцогч ТШЗ-ны 41.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ. Захиалагчийн тогтоох энэ хугацаа нь гэрээ байгуулах эрх олгосноос хойш ажлын 6 хоногийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтсан байна.

41.3. Шалгарсан тендерт оролцогч ТШЗ-ны 41.2-т заасан хугацааны дотор гэрээг зохих ёсоор баталгаажуулж, гүйцэтгэлийн баталгаа ирүүлсэн бол захиалагч гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах үүрэгтэй.

41.4. ТШЗ-ны 41.3-т заасан захиалагчийн үүрэг нь төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, бусад эрх бүхий этгээд, эсхүл шүүхээс гэрээ байгуулах эрх олгосон шийдвэрийг хуульд зааснаар хүчингүй болгосон, эсхүл хэрэгжилтийг түдгэлзүүлсэн тохиолдолд хамаарахгүй.

**Ё. БУСАД**

**42. Тендер шалгаруулалттай холбоотой гомдол**

42.1. Тендерт оролцогч тендер шалгаруулалттай холбоотой гомдлыг хууль тогтоомжийн дагуу гаргана.

**43. Урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулах тендер шалгаруулалт**

43.1. ТШЗ-ны 1.1-д заасан тендер шалгаруулалтыг урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулж байгаа үед энэ тухай ТӨХ болон тендерийн урилгад заана.

43.2. Захиалагч ТШЗ-ны 43.1-д заасны дагуу зохион байгуулах тендер шалгаруулалтад энэ тендерийн баримт бичгээс гадна “Урьдчилсан худалдан авах ажиллагааны журам”-д заасан нөхцөлийг мөрдөнө.

43.3. Урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулах тендер шалгаруулалтаар худалдан авах барааны санхүүжилтийн эх үүсвэр бүрэн батлагдах хүртэл гэрээ байгуулахгүй.

43.4. Худалдан авах барааны санхүүжилтийн эх үүсвэр батлагдаагүй, эсхүл цар хүрээ, хүчин чадлыг өөрчилж, төсөвт өртгийг ТШЗ-ны 2.1-т зааснаас өөрөөр баталсан бол урьдчилсан худалдан авах ажиллагааг хэрэгжих боломжгүй болсон гэж үзэж гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгоно.

43.5. ТШЗ-ны 43.4-т зааснаар гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгосонтой холбоотой аливаа эрсдэлийг тендерт оролцогч хариуцна.

**44. Тендер  
шалгаруулалтын  
мэдээллийг  
нийтлэх**

- 44.1. Тендер шалгаруулалттай холбоотой мэдээллийг хууль тогтоомжид заасны дагуу цахим системээр ил болгоно.
- 44.2. Захиалагч нээлтийн тэмдэглэл, тендер шалгаруулалтын үр дүнг цахим системд олон нийтэд ил тод мэдээлнэ.

## II БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

### Санамж

Захиалагч худалдан авах барааны онцлог шинж, тендерт оролцогчид тавигдах холбогдох хууль тогтоомж, түүний зарчимд нийцсэн шаардлага, шалгуур үзүүлэлтийг тендерийн өгөгдлийн хүснэгтэд тусгана.

Тендерийн өгөгдлийн хүснэгтийг боловсруулахад дараах зүйлийг анхаарна. Үүнд:

1. ТӨХ нь ТШЗ-ны зүйл, заалт болон түүнд хамаарах хэсгийг налуугаар бичсэн зааварт нийцүүлэн тохирох мэдээллийг нөхөх, гүйцээх зорилготой ба ТӨХ-д мөр нэмэхгүй, хасахгүй байх;
2. Тендерт оролцогчийн санхүүгийн болон техникийн чадавх, туршлагад тавих шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангаж буйг тогтоох зорилгоор шаардах баримт бичиг нь зөвхөн тендерт оролцогчийг тухайн бараа нийлүүлэх гэрээний үүргийг гүйцэтгэх чадавх, туршлагатай болохыг нотлох баримт бичиг байна;
3. ТШЗ-ны 18 дугаар зүйлд заасан баримт бичгүүдээс аль тохирох баримт бичгийг сонгож ТӨХ-д тусгайлан заана;
4. Тендерт оролцогч өөрийн тендерийн үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна. Иймд захиалагч хуулиар шаардсанаас бусад тохиолдолд тендерт хавсарган ирүүлэх баримт бичгийг нотариатаар гэрчлүүлэх, орчуулагчийн тэмдгээр баталгаажуулахыг тендерт оролцогчоос шаардахгүй;
5. Худалдан авах ажиллагааны цахим системтэй холбогдсон бусад мэдээллийн сангаас илгээсэн өгөгдлийг нотлох баримт бичгийг тендерт ирүүлэхийг шаардахгүй байх. Тухайлбал, Монгол Улсын хуулийн этгээдэд хамаарах улсын бүртгэлийн гэрчилгээ, тендерийн баталгаа, авто тээврийн хэрэгслийн эзэмшигчийн лавлагаа, санхүүгийн тайлан, татварын тодорхойлолт гэх мэт болно.

Энэхүү санамж нь хэм хэмжээ тогтоохгүй ба захиалагчаас батлах тендерийн баримт бичгийн хэсэг болохгүй.

**II БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ТӨХ)**

ТШЗ-ны холбогдох заалт	<b>А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</b>
ТШЗ 1.1	Захиалагч: <b>ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙРУУДЫН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР ТӨААТҮГ</b>
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр: <b>Барилгын цахилгаан, мужаан, сантехникийн урсгал засварын бараа материал худалдан авах</b>
ТШЗ 1.1	Тендерийн урилгын дугаар: <b>ЗГБНҮГ/202301006</b>
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>Багц № 1: Цахилгааны материал худалдан авах</b> <b>Багц № 2: Мужааны материал худалдан авах</b> <b>Багц № 3: Сантехникийн материал худалдан авах</b>
ТШЗ 1.3	Дотоодын үйлдвэрээс худалдан авах бараа байгаа бол тодорхой бич: <b>“Байхгүй”</b>
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: <b>“Өөрийн хөрөнгө”</b>
ТШЗ 2.1	Нийт төсөвт өртөг: <b>490.000.000 /дөрвөн зуун ерөн сая/ төгрөг</b> <b>Багц №1: 250.000.000 /хоёр зуун тавин сая/ төгрөг</b> <b>Багц №2: 140.000.000 /нэг зуун дөчин сая/ төгрөг</b> <b>Багц №3: 100.000.000 /нэг зуун сая/ төгрөг</b>
<b>Б. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА</b>	
ТШЗ 9.2	Тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг захиалагчид хүргүүлэх хаяг: <b>Хүлээн авагчийн нэр: Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга Д.Мичидгоо</b> <b>Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Ж.Самбуугийн гудамж, Засгийн газрын 11 дүгээр байр 1 дүгээр давхар, 110 тоот</b> <b>Утасны дугаар: 51-261596</b> <b>Цахим шуудангийн хаяг: <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>; <a href="mailto:info@bm-service.gov.mn">info@bm-service.gov.mn</a></b> <b>Тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийн хариуг хүсэлт гаргагчийн нэрийг дурдалгүйгээр албан бичгээр гаргаж, түүний хуулбарыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д нийтлэх</b>

	бөгөөд тус тодруулга, нэмэлт мэдээллийг бүх тендерт оролцогчдод нэгэн зэрэг хүргүүлсэнд тооцно. Иймд тендерт оролцохыг сонирхогч этгээдүүд дээрх цахим систем дэх тендерийн урилгын тодруулга, мэдээллийг байнга шалгахыг зөвлөж байна. Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах хугацааны хязгаар тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын 5 хоногоос багагүй байна.
<b>ТШЗ 10.1</b>	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: <b>“Үгүй”</b>
<b>В. ТЕНДЕР БЭЛТГЭХ</b>	
<b>ТШЗ 13.2</b>	Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний хувьд тендер шалгаруулалтын хэл: <b>“Монгол хэл”</b>
<b>ТШЗ 16.1</b>	Хувилбарт санал ирүүлэхийг: <b>“Зөвшөөрөхгүй”</b>
<b>ТШЗ 18.2</b>	Тендерт оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлага: <b>“Шаардана”</b>  Борлуулалтын орлогын хэмжээ: <b>2021, 2022 онуудын аль нэг жилийн борлуулалтын орлогын хэмжээ нь тухайн багцын батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгээс багагүй байна.</b>
<b>ТШЗ 18.2.5</b>	Санхүүгийн чадавхын талаар энэ зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангах бусад баримт: <b>“Шаардана.”</b>  1. Гэрээний үүргийн биелэлтийг хангах мөнгөн хөрөнгийн хэмжээ: <b>Тухайн багцын батлагдсан төсөвт өртгийн 50 хувиас багагүй байх.</b> Гэрээний үүргийн биелэлтийг хангах мөнгөн хөрөнгийн хэмжээг нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл нийлбэрээр тус тус тодорхойлно. Үүнд:  - Байгууллагын дансны үлдэгдэл /Харилцагч банкны/  - Арилжааны банкнаас авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт ирүүлнэ. (Банкны судлан үзэж зээл олгох боломжтой, зохих журмын дагуу зээл олгох боломжтой гэсэн утга бүхий тодорхойлолтыг үнэлгээнд харгалзахгүй )  - Үнэт цаас, Засгийн газрын бонд болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан үнэт цааснууд;  2. Харилцагч банкнаас хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн өр, төлбөргүй талаарх тодорхойлолтыг ирүүлнэ
<b>ТШЗ 18.3</b>	Тендерт оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацаа: 2021, 2022 онуудын санхүүгийн тайланг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Сангийн яамны цахим санхүүгийн тайлангийн <a href="http://www.ebalance.mof.gov.mn">www.ebalance.mof.gov.mn</a> мэдээллийн системээс тендерт оролцогчдын сүүлийн 2 жилийн борлуулалтын орлого, болон бусад шаардлагатай мэдээллийг шалгана.

ТШЗ 18.6	<p>Тендерт оролцогчийн техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлага:</p> <p>Ижил төстэй гэрээний туршлага: <b>2021, 2022 онуудын аль нэг жилд тухайн багцын батлагдсан төсөвт өртгийн 60 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй барааг доод тал нь нэг удаа нийлүүлсэн байх шаардлагатай.</b></p> <p>Бараа нийлүүлсэн гэрээний хуулбар, хүлээлгэж өгсөн актын хуулбар, тухайн барааг цаг хугацаанд нь чанартай нийлүүлсэн талаарх захиалагчийн тодорхойлолтыг ирүүлнэ.</p> <p>Ижил төстэй ажилд тухайн бараа болон түүнтэй дүйцэхүйц бараа нийлүүлсэн туршлагыг тооцно.</p>
ТШЗ 18.6.1	Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: <b>“Шаардахгүй”</b>
ТШЗ 18.6.3	<p>Барааг дагалдах үйлчилгээг хэрэгжүүлэх хүний нөөцийн мэдээлэл: <b>“Шаардана”</b></p> <p><b>Бараа материалын нийлүүлэлтийг хариуцсан удирдах гүйцэтгэлд хяналт тавих ажилтан болон хүргэлтийн 2 оос доошгүй үндсэн ажилтантай байх. Ажилтнуудын мэдээлэл болон НД-8 маягт цахим лавлагаа ирүүлэх. (2022 оны 08,09,10,11,12 сар, 2023 оны 01 дүгээр сарууд хамаарна.)</b></p>
ТШЗ 18.6.4	Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний мэдээлэл: <b>2021, 2022 онуудад ижил төстэй бараа нийлүүлж байсан талаарх гэрээний мэдээллийг маягт 5, маягт 7 -ын дагуу ирүүлэх</b>
ТШЗ 18.6.7	<p>Бараа нийлүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: <b>“Шаардана”</b></p> <p><b>Тухайн барааг цаг хугацаанд нь нийлүүлэхэд шаардлагатай 1-ээс доошгүй тээврийн хэрэгсэл болон тээвэр ложилстикийн бэлэн байдлыг нотлох баримт, мэдээлэл ирүүлэх (Тээврийн хэрэгслийн гэрчилгээ, түрээсээр ашиглах тохиолдолд нотариатаар баталгаажуулсан түрээсийн гэрээгээр нотлоно )</b></p>
ТШЗ 18.6.8	<p>Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад баримт: <b>“Шаардана”</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Үнийн санал маягтын дагуу ирүүлэх</li> <li>• Байнгын ажиллагаатай дэлгүүр, лангуутай байх /нотлох бичиг баримтын хамт ирүүлэх/</li> <li>• Барааны үнийн задаргаа ба бараа нийлүүлэлтийн хуваарийг маягтын дагуу баталгаажуулан ирүүлнэ</li> <li>• НӨАТ-н гэрчилгээний хуулбар ирүүлэх</li> <li>• Байгууллагын дэлгэрэнгүй танилцуулга ирүүлэх</li> <li>• Гэрээний ерөнхий нөхцөл, гэрээний тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн тухай албан бичиг ирүүлэх</li> <li>• Захиалагч болон нийлүүлэгчийн нийлүүлэх барааны техникийн тодорхойлолтыг харьцуулсан байдлаар дэлгэрэнгүй танилцуулга,</li> </ul>



	<p>хүснэгтээр бэлтгэж фото зураг, чанарын үзүүлэлт зэргийг баталгаажуулан ирүүлэх</p> <ul style="list-style-type: none"> <li>• Тендерт оролцогч нь татварын байгууллага, нийгмийн даатгалын байгууллага, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, харилцагч банк болон бусад эрх бүхий байгууллагаас лавлагаа авахад татгалзах зүйлгүй тухай албан бичиг ирүүлэх</li> <li>• Тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ болон хугацаанд багтаан чанарын шаардлага хангасан барааг захиалагчид нийлүүлэх баталгааг албан бичгээр гаргаж ирүүлэх.</li> </ul> <p><i>Тендерийн баримт бичиг нь үнэн зөв, тодорхой гаргацтай байна. Унших боломжгүй, тодорхойгүйн улмаас үнэлгээ хийх боломжгүй нөхцөл байдал үүсэхээр бол үнэлгээний хороо нь уг тендерээс татгалзах үндэслэл болно.</i></p>
<b>ТШЗ 18.7.</b>	Тендерт оролцогч, түүний түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл: <b>“Шаардахгүй”</b>
<b>ТШЗ 19.5.</b>	Барааны хувьд тасралтгүй, горимын дагуу ажиллуулахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад эд зүйлсийн жагсаалт ирүүлэх хугацаа: <b>“Шаардахгүй”</b>
<b>ТШЗ 20.5.</b>	Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: <b>“Тохируулахгүй”</b>
<b>ТШЗ 20.6</b>	<p>Олон улсын худалдааны нөхцөлийг хэрэглэх эсэх: <b>Incoterms 2020, DDP, бараа хүргэх газар</b></p> <p><b>Бүх багцад хамаарна: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Ж.Самбуугийн гудамж, Засгийн газрын XI байрын В1 давхарын агуулахад, Улаанбаатар хот, Засгийн газрын харьяа байрууд</b></p>
<b>ТШЗ 23.1</b>	<p>Тендерийн баталгааны дүн: <b>“Шаардана”</b></p> <p><b>Багц №1: 1.250.000 [нэг сая хоёр зуун тавин мянга] төгрөг;</b></p> <p><b>Багц №2: 700.000 [долоон зуун мянга] төгрөг</b></p> <p><b>Багц №3: 500.000 [таван зуун мянга] төгрөг</b></p> <p>Хүчинтэй байх хугацаа: <b>Тендерийн хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй байна.</b></p> <p><i>Анхааруулга: Цахим тендерт оролцогч тендерийн материалд цахим тендерийн баталгааг хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан гаргасан цахим тендерийн баталгааны мэдээлэл үнэн зөв эсэхийг шалгах, нягтлах үүрэгтэйг анхаарна уу.</i></p>
<b>Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ</b>	
<b>ТШЗ 24.5.3</b>	<p>ТШЗ-ны 17 дугаар зүйлд заасан болон V бүлгийн маягтуудаас гадна бусад тендерт оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:</p> <p><b>[Анхааруулга: тендерт оролцогч тендерийн материалд хувь хүний мэдээллийг хамгаалах тухай болон байгууллагын нууцын тухай</b></p>

	<p><i>хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ.</i></p> <p><i>Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна.</i></p> <p><i>Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.</i></p>
<b>ТШЗ 25.1.</b>	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: <b>2023 оны 03 дугаар сарын 17-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>14 цаг 00 минут</b></p>
<b>ТШЗ 27.1.</b>	<p>Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг тендерт оролцогч цахим системээр хүлээн авна.</p> <p>Огноо: <b>2023 оны 03 дугаар сарын 17-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>14 цаг 30 минут</b></p> <p>Тендер нээх газрын хаяг: <b>Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Ж.Самбуугийн гудамж, Засгийн газрын XI байр 1-р давхар 110 тоот</b></p>
<b>Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ</b>	
<b>ТШЗ 31.2</b>	<p>Үнэлгээнд харгалзах нэмэлт шалгуур үзүүлэлт ашиглах эсэх: <b>“Ашиглахгүй”</b></p>
<b>Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ</b>	
<b>ТШЗ 40.1</b>	<p>Шалгарсан тендерт оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: <b>“Тийм”</b></p> <p><b>ТШЗ-ны 8.5-т заасан гэрээний нөхцөлийн дагуу гүйцэтгэлийн баталгаа ирүүлнэ.</b></p>
<b>Ё. БУСАД</b>	
<b>ТШЗ 43.1</b>	<p>Урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдаж байгаа эсэх: <b>“Үгүй”</b></p>

### III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

*[Захиалагч болон үнэлгээний хороо нь худалдан авах барааны техникийн тодорхойлолтыг боловсруулахад энэхүү санамжийг ашиглана.*

*Техникийн тодорхойлолтын зорилго нь захиалагчид шаардлагатай барааг нарийвчлан тодорхойлоход оршино. Уг санамж нь хэм хэмжээ тогтоохгүй ба захиалагчаас батлах тендерийн баримт бичгийн хэсэг болохгүй.*

- Ойлгомжтой сайтар бэлтгэсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд тендерт оролцогчдод зайлшгүй чухал нөхцөл болно.*
- Техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд өрсөлдөөнийг өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд худалдан авах барааны шинж чанар, материал, үйл ажиллагааны шаардагдах стандартын талаар тодорхой тусгана. Эдгээрийг хангасан нөхцөлд худалдан авах ажиллагааны хэмнэлттэй, үр ашигтай, шударга байх зорилго хэрэгжиж, тендерүүдийн шаардлагад нийцэх байдал баталгаажиж, тендерийн үнэлгээ зөв хийгдэнэ.*
- Техникийн тодорхойлолт боловсруулахдаа батлагдсан төсөвт багтаан эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байх үзүүлэлтийг тусгаж өгнө.*
- Тендерийн баримт бичигт зааснаас бусад тохиолдолд бүх бараа, материал нь шинэ, ашиглагдаагүй, сүүлийн үеийн технологи зэргийг хангасан байх нөхцөлийг шаардана. Өмнө хэрэгжсэн, ижил төстэй төслийн техникийн тодорхойлолтыг жишээ болгон ашиглах нь давуу талтай.*
- Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй. Барааны тэмдэг, нэр, хэлбэр маяг, төрөл, гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайлан заасан шаардлага, нөхцөлийг заах шаардлагатай бол түүний ард “эсхүл түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглэнэ.*
- Бараа материалын, техникийн тодорхойлолтод аль болох олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хэрэглэх шаардлагатай. Хэрэв Монгол Улсын үндэсний стандарт, эсхүл тухайлсан өөр стандартыг хэрэглэсэн тохиолдолд бараа материал, шинж чанар нь энэ стандартад дүйцэх буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрнө гэж техникийн тодорхойлолтод заах хэрэгтэй.*

#### **Зураг, төсөл**

*Шаардлагатай бол барааны эскиз, зургийг хавсаргана.*

## **Шалгалт, туршилт**

*[Захиалагч тендерт оролцогчоос нийлүүлэх гэж буй бараанд үйлдвэрийн болон бусад шалгалт, туршилт хийсэн болохыг нотлох баримт, үүнтэй холбоотой мэдээлэл ирүүлэхийг шаардаж болно.*

*Шаардлагатай тохиолдолд захиалагч загвар, дээжийг шалгаж, туршиж болох ба шалгалт, туршилт хийсний үр дүнд тухайн загвар, дээжийн үндсэн шинж чанар алдагдсан, зориулалтын дагуу дахин ашиглах боломжгүй болсон тохиолдолд тендерт оролцогчид буцааж олгохгүй тухай техникийн тодорхойлолтод заана. Бусад тохиолдолд гэрээ байгуулсны дараа шалгарсан тендерт оролцогчийн загвар, дээжээс бусад загвар, дээжийг буцааж олгоно.*

*Загвар, дээжийг хэрхэн шалгах, турших тухай тодорхой заана.]*

## Техникийн тодорхойлолт

Нийлүүлэх бараа нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

Барааны нэр: .....

<b>№</b>	<b>Захиалагчийн техникийн тодорхойлолт</b> (Тухайн барааны үзүүлэлт тус бүрийг дор жагсааж бичих ба хэрвээ чанарын баталгаат хугацаа шаардах бол бичнэ үү.)	<b>Санал болгож буй техникийн тодорхойлолт</b> (захиалагчийн техникийн тодорхойлолтыг хуулахгүй байхыг анхаарна уу. Зөвхөн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг бичнэ үү.)	<b>Тайлбар</b> (дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцуулгыг хавсаргана)
1			
2			
3			
...			

**[Үнэлгээний хороо худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д нийтэлсэн техникийн тодорхойлолтын жишиг нөхцөл, стандарт, загварыг баримтлан техникийн тодорхойлолтыг боловсруулна.]**

БАТЛАВ:  
 ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙРУУДЫН НИЙТЛЭГ  
 ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН БАРИЛГА,  
 ИНЖЕНЕР ТЕХНИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА  
 Х.ҮЛ-ОЛДОХ

Цахилгаан хангамжын бараа материалын техникийн тодорхойлолт				
Д/Д	Материалын нэр төрөл	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Техникийн тодорхойлолт
1	гэрэл гуурсан 60см	100	ш	Өдрийн /Люминесцент / гэрэл нь хэлбэр дүрс, загварын төрлөөс үл хамааран 3000-с дээш цаг асдаг, 220 вольтод ажилладаг бөгөөд ±5%-ийн хувьсах хүчдэлийн хэлбэлзэлд хэвийн ажилладаг байх. / Монгол улсын стандартад нийцсэн ба түүнээс дээш чанартай байна
2	гэрэл гуурсан 90см	100	ш	
3	гэрэл гуурсан 120см	100	ш	
4	гэрэл мушгиа 40вт	150	ш	
5	гэрэл мушгиа 20вт	150	ш	
6	гэрэл мушгиа 85вт	10	ш	Өдрийн /Улайсах / гэрэл нь хэлбэр дүрс, загварын төрлөөс үл хамааран 600-с дээш цаг асдаг, 220 вольтод ажилладаг бөгөөд ±5%-ийн хувьсах хүчдэлийн хэлбэлзэлд хэвийн ажилладаг байх, Монгол улсын стандартад нийцсэн ба түүнээс дээш чанартай байна.
7	гэрэл ердийн	100	ш	
8	гэрэл 500вт	20	ш	
9	Өдөөгч	1000	ш	
10	Гэрлийн шаазан потрон	50	ш	
11	Гэрэл мэдрэгчтэй	50	ш	
12	гэрэл ар нь нарийн	100	ш	
13	гэрэл зулан лед	100	ш	
14	лед 3вт далд	100	ш	
15	лед 4вт далд	100	ш	
16	лед 6вт далд	100	ш	
17	лед 9вт далд	100	ш	
18	лед 12вт далд	100	ш	
19	лед 15вт далд	100	ш	
20	лед 18вт далд	100	ш	
21	лед 24вт далд	100	ш	
22	лед гэрэл 6 вт ил	200	ш	
23	лед гэрэл 12 вт ил	100	ш	
24	лед гэрэл 18 вт ил	100	ш	
25	лед гэрэл 24 вт ил	100	ш	
26	лед 6вт далд /арын тогтоогч гүйдэг/	100	ш	
27	лед 8вт далд /арын тогтоогч гүйдэг/	100	ш	
28	лед 15вт далд /арын тогтоогч гүйдэг/	100	ш	
29	лед 20вт далд /арын тогтоогч гүйдэг/	100	ш	
30	Лед шилэн хүрээтэй 6вт	100	ш	Лед гэрэл нь хэлбэр дүрс, загварын төрлөөс үл хамааран 5000-с дээш цаг асдаг, 220 вольтод ажилладаг бөгөөд ±5%-ийн хувьсах хүчдэлийн хэлбэлзэлд хэвийн ажилладаг байх, Монгол улсын стандартад нийцсэн ба түүнээс дээш чанартай байна.
31	Лед шилэн хүрээтэй 9вт	100	ш	
32	Лед шилэн хүрээтэй 12вт	100	ш	
33	Лед шилэн хүрээтэй 18вт	100	ш	
34	нэмэх лед суурь 72вт	150	ш	
35	Хасах лед суурь 36вт	100	ш	
36	Гэрэл замтай 12вт	20	ш	
37	Гэрэл туузан	10	м	
38	Гэрэл лед 30x60 далд	50	ш	
39	Гэрэл лед 30x60 ил	50	ш	
40	Гэрэл лед 30x120 далд 120вт	40	ш	
41	Гэрэл лед 30x120 ил	40	ш	

42	Гэрэл лед 40x40 далд	100	ш	
43	Гэрэл лед 40x40 ил	100	ш	
44	Гэрэл лед 50x50 далд	200	ш	
45	Гэрэл лед 50x50 ил	200	ш	
46	гэрэл 60x60 лед 96вт (далд)	200	ш	
47	гэрэл лед 60x60 96вт (ил)	200	ш	
48	гэрэл лед 60x60 96вт (гипсэн таазны)	200	ш	
49	лед гэрэл 10x120см ил	200	ш	
50	Гэрэл лед 20x120см ил	300	ш	
51	Прожектор 50вт лед	15	ш	Лед прожектор нь хэлбэр дүрс, загварын төрлөөс үл хамааран 5000-с дээш цаг асдаг, 220 вольтод ажилладаг бөгөөд ±5%-ийн хувьсах хүчдэлийн хэлбэлзэлд хэвийн ажилладаг байх, ус, чигний хамгаалалтын зэрэг IP-66-аас дээш, Монгол улсын стандартад нийцсэн ба түүнээс дээш чанартай байна.
52	Прожектор 100вт лед	10	ш	
53	Прожектор 150вт лед	5	ш	
54	Прожектор 200вт лед	50	ш	
55	олон утастай трансформатор	200	ш	220 вольтод ажилладаг бөгөөд ±5%-ийн хувьсах хүчдэлийн хэлбэлзэлд хэвийн ажилладаг байх, зарим тохиолдолд ус, чигний хамгаалалтын зэрэг өндөртэй, Монгол улсын стандартад нийцсэн ба түүнээс дээш чанартай байна.
56	Лед гэрлийн трансформатор	150	ш	
57	Трансформатор 12вт	100	ш	
58	розетка /далд/ 1тэй	10	ш	Розетка нь ил, далд, нэгтэй, хоёртой гэх мэт загварын төрлөөс үл хамааран дамжуулах хэвийн гүйдлийн хамгийн бага утга нь 16А байх бөгөөд гадна их бие нь хуванцар, метал, хуванцар болон метал холимог хийцтэй байж болох ба хуванцар хийц нь шаталтыг дэмждэггүй, цахилгаан тусгаарлах шинж чанар өндөртэй байна. Усны хамгаалалттай розетка нь IP65-ын хамгаалалтын зэрэгтэй, Монгол улсын стандартад нийцсэн ба түүнээс дээш чанартай байна.
59	розетка /ил/ 1тэй	10	ш	
60	розетка /далд/ 2той	10		
61	розетка /ил/ 2той	10		
62	розетка /шалны/	40	ш	
63	унтраалга /далд/ 1тэй	10	ш	Унтраалга нь ил, далд, нэгтэй, хоёртой гэх мэт загварын төрлөөс үл хамааран дамжуулах хэвийн гүйдлийн хамгийн бага утга нь 10А байх бөгөөд гадна их бие нь хуванцар, метал, хуванцар болон метал холимог хийцтэй байж болох ба хуванцар хийц нь шаталтыг дэмждэггүй, цахилгаан тусгаарлах шинж чанар өндөртэй байна. Усны хамгаалалттай унтраалга нь IP65-ын хамгаалалтын зэрэгтэй, Монгол улсын стандартад нийцсэн ба түүнээс дээш чанартай байна.
64	унтраалга /далд/ 2тэй	10		
65	унтраалга /далд/ 3тэй	10		
66	унтраалга /ил/ 1тэй	10		
67	унтраалга /ил/ 2тэй	10		
68	кроп 2-той	80	ш	Хуванцар кроп халуунд тэсвэртэй гал дэмждэггүй чанар сайтай, монгол улсын стандартад нийцсэн ба түүнээс дээш чанартай байна.
69	кроп 3 чихтэй ил	50	ш	
70	вилк	200	ш	
71	Сэнс 10x10см ф100	50	ш	Чанар сайтай, монгол улсын стандартад
72	Сэнс 20x20см	30		
73	Сэнс 30x30см	20		
74	Сэнс 40x40см	20		


75	Сэтгэ 18x25	30	ш	нийцсэн ба түүнээс дээш чанартай байна.	
76	Сэтгэ 30x30	20			
77	Лүүкний таг төмөр 40x40	10			
78	Лүүкний таг төмөр 60x60	10			
79	Клем 4фазын 200 А	10	ш	Чанар сайтай, монгол улсын стандартад нийцсэн ба түүнээс дээш чанартай байна.	
80	Клем 1 фазын /УК-50А/	100	ш		
81	изолятор	50	ш		
82	клем 00 н	40	ш	Чанар сайтай, монгол улсын стандартад нийцсэн ба түүнээс дээш чанартай байна.	
83	клем газардуулга	30	ш		
84	00-н клем 50А /автомат шиг хавчдаг/	40	ш		
85	примечка 1 фаз 25А	10	ш	Чанар сайтай, монгол улсын стандартад нийцсэн ба түүнээс дээш чанартай байна.	
86	примечка 2фаз 63А	10	ш		
87	примечка 3 фаз 100А	40	ш		
88	автомат 1фаз 16А	100	ш	Автомат таслуур нь тоног төхөөрөмжүүдийг хэт ачаалал, богино залгааны гүйдлээс маш богино хугацаанд хэлхээг тасалдаг, компьютер, электроникийн нарийн мэдрэмтгий тоноглолд зориулагдсан байх, Монгол улсын стандартад нийцсэн ба түүнээс дээш чанартай байна.	
89	автомат 1фаз 25А	100	ш		
90	автомат 1фаз 32А	100	ш		
91	автомат 1фаз 63А	30	ш		
92	2 фазын автомат 16А	20	ш		
93	2 фазын автомат 25А	20	ш		
94	2 фазын автомат 32А	20	ш		
95	автомат 3фаз 16А	10	ш		
96	автомат 3фаз 25А	10	ш		
97	автомат 3фаз 32А	10	ш		
98	автомат 3фаз 63А	15	ш		
99	автомат 3фаз 100А	10	ш		
100	депринцал автомат /16А /	20	ш		
101	депринцал автомат /25А /	20	ш		
102	депринцал автомат /32А /	20	ш		
103	3-н фазын хүчний автомат /32А /	50	ш		50Гц-ийн давтамжтай 690В хүртлэх ажлын хэвийн хүчдэлтэй, 30А-250А хүртлэх хэвийн гүйдэл дэхь цахилгаан тоноглолыг залгаатай горимд гүйдлийг дамжуулах, богино залгааны ихсэх гүйдэл, хэт ачааллын таслагч нь дулаан ба цахилгаан соронзон үйлчлэлтэй, зарим тохиолдолд таслуурын гүйдлийн тохируулагатай, зөвшөөрөгдөөгүй хүчдэл бууралтын үед цахилган хэлхээний хэсгийг хамгаалан салгах зориулалттай, Евро стандартад нийцсэн ба түүнээс дээш чанартай байна.
104	3-н фазын хүчний автомат /63А /	50	ш		
105	3-н фазын хүчний автомат /80А /	50	ш		
106	3-н фазын хүчний автомат /100А/	10	ш		
107	3-н фазын хүчний автомат /160А /	20	ш		
108	3-н фазын хүчний автомат /250А /	20	ш		
109	автомат зам	20	ш	Чанар сайтай, монгол улсын стандартад нийцсэн ба түүнээс дээш чанартай байна.	
110	автомат хайрцаг /хуванцар 12 автомат орох/	10	ш		
111	автомат хайрцаг /хуванцар 6 автомат орох/	10	ш		
112	Хайрцаг 50x60x20 далд	5	ш	Төмөр сайтай, сайн чанарын, зэврэлтээс хамгаалах түрхлэгтэй, Монгол улсын стандартад нийцсэн ба түүнээс дээш чанартай байна.	
113	Хайрцаг 50x60x20 ил	10	ш		
114	Хайрцаг 30x40x20 далд	5	ш		
115	Хайрцаг 30x40x20 ил	10	ш		
116	Хайрцаг 1200x600x160	2	ш		
117	Тооллуур 100А 3 фазын тарифтай	5	ш	Чанар сайтай, монгол улсын стандартад нийцсэн ба түүнээс дээш чанартай байна.	
118	Контактор18квт	10	ш		
119	Реле /дулааны/	10	ш		
120	Термодачик	15	ш		
121	Дулааны мэдрүүр	15	ш		
122	Лент /цахилгааны/	200	ш		



123	Cat 6 УТП	10	х	
124	Хөнгөнцагаан утас 2x2,5мм <sup>2</sup>	200	м	MNS IEC 60050-461 : 2019 стандартын шаардлага хангасан хөнгөн цагааны агууламж өндөртэй байх.
125	Хөнгөнцагаан утас 2x4мм <sup>2</sup>	100	м	
126	Хөнгөнцагаан кабель 4x16мм <sup>2</sup>	200	м	
127	Хөнгөнцагаан кабель 4x25мм <sup>2</sup>	200	м	
128	ППВ 2x2,5мм <sup>2</sup>	10	м	
129	ППВ 2x4мм <sup>2</sup>	10	м	MNS IEC 60050-461 : 2019 стандартын шаардлага хангасан зэсийн агууламж өндөртэй байх.
130	ПУНУГ 2x2,5 мм <sup>2</sup>	10	м	
131	ПУНУГ 2x4мм <sup>2</sup>	10	м	
132	Провод 1x4 мм <sup>2</sup>	10	м	
133	Провод 1x6 мм <sup>2</sup>	10	м	
134	провод 1x10мм <sup>2</sup>	10	м	
135	провод 1x16 мм <sup>2</sup>	10	м	
136	Провод 1x25 мм <sup>2</sup>	10	м	
137	Провод 1x35 мм <sup>2</sup>	100	м	
138	КГ 2x2.5 мм <sup>2</sup>	10	м	
139	КГ 2x4 мм <sup>2</sup>	10	м	
140	КГ 4x6 мм <sup>2</sup>	10	м	
141	уртасгагч даацын 10м	6	ш	Чанар сайтай, монгол улсын стандартад нийцсэн ба түүнээс дээш чанартай байна
142	Уртасгагч /дамар 50м/	10	ш	
143	кембрик /4 шин /	30	м	Халалтанд тэсвэртэй, гал дэмждэггүй чанар сайтай, монгол улсын стандартад нийцсэн ба түүнээс дээш чанартай байна
144	CD хар хоолой 16-н	20	б	
145	CD хар хоолой 22-н	15	б	
146	CD хар хоолой 32-н	10	б	
147	Төгсгөвч хөнгөн цагаан 10мм	200	ш	Гилц, төгсгөвчүүд нь зэс ба хөнгөн цагааны агууламж өндөртэй, сайн чанарын байх ба Монгол улсын стандартад нийцсэн ба түүнээс дээш чанартай байна.
148	Төгсгөвч хөнгөн цагаан 16мм	200	ш	
149	Төгсгөвч хөнгөн цагаан 25мм	100	ш	
150	Төгсгөвч хөнгөн цагаан 35мм	30	ш	
151	Төгсгөвч хөнгөн цагаан 50мм	20	ш	
152	Төгсгөвч хөнгөн цагаан 75мм	20	ш	
153	Төгсгөвч хөнгөн цагаан 95мм	20	ш	
154	Төгсгөвч хөнгөн цагаан 120мм	20	ш	
155	Төгсгөвч хөнгөн цагаан 150мм	20	ш	
156	Төгсгөвч хөнгөн цагаан 185мм	20	ш	
157	Төгсгөвч зэс 10 мм	100	ш	
158	Төгсгөвч зэс 16 мм	150	ш	
159	Төгсгөвч зэс 25 мм	100	ш	
160	Төгсгөвч зэс 35 мм	50	ш	
161	Төгсгөвч зэс 50 мм	50	ш	
162	Төгсгөвч зэс 75 мм	50	ш	
163	Төгсгөвч шулуун 2.5 мм	5	уут	
164	Төгсгөвч шулуун 4 мм	5	уут	
165	Төгсгөвч шулуун 6 мм	5	уут	
166	Төгсгөвч шулуун 10 мм	5	уут	
167	Төгсгөвч шулуун 16 мм	5	уут	
168	Гилц 16 хөнгөн цагаан	20	ш	
169	Гилц 25 хөнгөн цагаан	10	ш	
170	Гилц 35 хөнгөн цагаан	10	ш	
171	Гилц 16 зэс	10	ш	
172	Гилц 25 зэс	10	ш	
173	Гилц 35 зэс	10	ш	
174	Шалны далдлагч наадаг /1 утасны/	100	ш	
175	Шалны далдлагч наадаг /2 утасны/	100	ш	
176	Шалны далдлагч наадаг /4 утасны/	100	ш	

177	Шалны далдлагч наадаг /6 утасны/	100	ш	Халалтанд тэсвэртэй, гал дэмждэггүй чанар сайтай, монгол улсын стандартад нийцсэн ба түүнээс дээш чанартай байна
178	Далдлагч 2 метр /2 утас/	100	ш	
179	Далдлагч 2 метр /4 утас/	100	ш	
180	шалны далдлагч төмөр наадаг / 2 утасны/	100	ш	
181	шалны далдлагч төмөр наадаг / 4 утасны/	100	ш	
182	шалны далдлагч төмөр наадаг / 6 утасны/	50	ш	
183	Цэгэн уяа	5	б	Чанар сайтай, монгол улсын стандартад нийцсэн ба түүнээс дээш чанартай байна
184	бетоны ир бавлиттай	10	ш	Чанар сайтай, монгол улсын стандартад нийцсэн ба түүнээс дээш чанартай байна
185	Төмрийн шрүп 1.5	20	х	
186	Тэлэгч 6	100	у	Чанар сайтай, монгол улсын стандартад нийцсэн ба түүнээс дээш чанартай байна
187	Тэлэгч 8	50	у	
188	Клемний овтерка /нэмэх, хасах сольдог/	10	ш	Төмөр сайтай, Монгол улсын стандартад нийцсэн ISO 9001-2016 стандартын шаардлагыг хангасан ба түүнээс дээш чанартай байх
189	Цахилгааны овтерка /нэмэх/	10	ш	
190	Цахилгааны овтерка /хасах/	10	ш	
191	Бахь	10	ш	
192	Бахь /нарийн хошуутай/	10	ш	
193	Кусочка	10	ш	
194	Тунгалаг нүдний шил	10	ш	Чанар сайтай, монгол улсын стандартад нийцсэн ба түүнээс дээш чанартай байна
195	Гүйдлийн индикатор	10	ш	
196	Ампер клеш /400А/	5	ш	
197	Ажлын бээлий	1000	ш	Алгандаа резинтэй Монгол улсын стандартад нийцсэн ба түүнээс дээш чанартай байна

Боловсруулсан: Цахилгааны инженер



Н.Наранцогт

БАТЛАВ  
 ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙРУУДЫН НИЙТЛЭГ  
 ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН БАРИЛГА, ИНЖЕНЕР  
 ТЕХНИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА  
 Х.УЛ-ОЛДОХ

	Материалын нэр төрөл	Хэмжих нэгж	тоо ширхэг	Тайлбар
1	Багс жижиг	ш	20	Үс нь унадаггүй, сатуркан биш үстэй, төрөл бүрийн хэмжээтэй, солонгос улсад үйлдвэрлэсэнтэй дүйцэхүйц сайн чанарын байх
2	Багс дунд	ш	20	
3	Багс том	ш	15	
4	Өнхрүүш жижиг	ш	20	Засварын явцад үс нь унадаггүй, сайн чанартай, эдэлгээ даах, эсхүл солонгос улсад үйлдвэрлэсэн шар иштэй өнхрүүштэй дүйцэхүйц байх
5	Өнхрүүш том	ш	20	
6	Өнхрүүшний иш	ш	4	Урт сунадаг, төмөр сайтай, удаан эдэлгээтэй байх
7	Шпатель /хуванцар/	ш	30	Монгол улсын стандартад нийцсэн ISO 9001-2016 стандартын шаардлагыг хангасан ба түүнээс дээш чанартай байх
8	Шпатель /төмөр/ жижиг	ш	10	
9	Шпатель /төмөр/ том	ш	6	
10	Төмөр ниве	ш	8	
11	Цаасан наалт өргөн	ш	70	
12	Гялгар наалт том	ш	60	Гулгалт, барьцалдах чадвар сайн, -50 хэм +50 хэмд тэсвэртэй. 25 кг савлагаатай, ISO 9001 шаардлага хангасан байх. MNS 5526 : 2005 стандарт
13	Замаска цагаан	уут	15	
14	Замаска хар	уут	8	
15	Замаска гадна	уут	5	25 кг савлагаатай, хурдан бэхждэг, сайн чанартай байх
16	Кнап	уут	10	Монгол улсын стандартад нийцсэн ISO 9001-2016 стандартын шаардлагыг хангасан ба түүнээс дээш чанартай байх
17	Гипс нунтаг	кг	10	Монгол улсын стандартад нийцсэн байх. OPC 42.5 портланд цементтэй дүйцэхүйц монгол улсын стандартад нийцсэн байх. MNS GB 175 : 2019 стандарт хангасан байх
18	Цемент	уут	120	Монгол улсын стандартад нийцсэн, чанарын шаардлагыг хангасан ба түүнээс дээш чанартай байх. MNS 0346:2000 стандарт хангасан байх
19	Хайрга 0.5	уут	250	Монгол улсын стандартад нийцсэн, чанарын шаардлагыг хангасан ба түүнээс дээш чанартай байх. MNS 0346:2000 стандарт хангасан байх
20	Элс	уут	50	Монгол улсын стандартад нийцсэн, чанарын шаардлагыг хангасан ба түүнээс дээш чанартай байх
21	Эмульс 4л дотор	ш	30	Өтгөн будах чанар өндөртэй. Үнэргүй, хүний биед харшил үүсгэхгүй, байгаль орчинд ээлтэй. Агаар чөлөөтэй нэвтрүүлдэг. Ус чийг, хүчиллэг орчинд тэсвэртэй, хөгц, мөөгөнцөр үүсгэхгүй. Тархац сайтай, уусгагч бодис агуулаагүй. Өнгө оруулагч пигмент ашиглан хүссэн өнгөө гаргаж болно. Тогтоц сайтай өнгө гандахгүй. Бүх төрлийн стандартуудыг бүрэн хангасан байх. MNS 5252 : 2003 стандартад нийцсэн байх
22	Эмульс 18л дотор	ш	40	
23	Эмульс 4л гадна	ш	4	
24	Эмульс 10л дотор	ш	4	

25	Хувин том	ш	2	бат бах удаан эдэлгээтэй зузаан материалтай байх
26	Будаг төмөр	кг	10	Бүх төрлийн өнгөтэй ОХУ-ын ЯРКО брэндийн будагтай дүйцэхүйц сайн чанартай байх
27	Будаг мод	кг	30	
28	Будаг шүршдэг	ш	15	сайн чанарын савалгаатай бүх төрлийн өнгөтэй БНСУ-ын Spray брэндийн будагтай дүйцэхүйц сайн чанартай байх
29	Будаг шингэлэгч	ш	30	будаг шингэлэгч ОХУ-ын растворитель 646, дүйцэхүйц сайн чанарын ISO 9001 шаардлага хангасан байх
30	Пигмент жижиг	ш	30	будаг, эмульс, замаска зэрэг барилгын засал чимэглэлийн материалд хольж хэрэглэдэг төрөл бүрийн өнгөтэй, 100 мл савлагаатай ISO 9001 шаардлага
31	Лак 1л	л	15	Бүх төрлийн савалгаатай сайн чанартай байх, -50 С-ээс +60 С-аас температурын өөрчлөлтийг тэсвэрлэх чадвартай
32	Силикон дотор	ш	100	Гадаргууд сайн наалддаг, өндөр температурт тэсвэртэй.
33	Силикон хиаман	ш	50	
34	Силикон лаан бууны	боодол	10	
35	Силикон бууны гар	ш	10	Монгол улсын стандартад нийцсэн ISO 9001-2016 стандартын шаардлагыг хангасан ба түүнээс дээш чанартай байх
36	Шингэн хадаас	ш	50	наалдац сайтай, сайн чанартай байх
37	Хөөс гадна	ш	30	SMART FOAM солонгос хөөстэй дүйцэхүйц сайн чанарын шахалт сайтай байх
38	Хөөс дотор	ш	60	
39	Зүлгүүр	м	100	Олон төрлийн сонголттой, Монгол улсын стандартад нийцсэн ба түүнээс дээш чанартай байх
40	Зүлгүүрийн гар	ш	10	
41	ДСП хавтан	ш	20	
42	Гипсэн хавтан 1.2мм	ш	30	1.22 x 2.44м, 1.2 см зузаантай. ОХУ -д үйлдвэрлэсэн хавтантай дүйцэхүй байх
43	Акустик хавтан	ш	30	Монгол улсын стандартад нийцсэн нягт өндөртэй ISO 9001-2016 стандартын шаардлагыг хангасан ба түүнээс дээш чанартай байх
44	Хөөсөнцөр	ш	20	1 x 2м, 10 см зузаантай нягт өндөртэй, Монгол улсын стандартад нийцсэн ISO 9001-2016 стандартын шаардлагыг хангасан ба түүнээс дээш чанартай байх
45	Лампир	м.кв	10	Бат бөх чанартай, зузаан, удаан эдэлгээтэй байх, Монгол улсын стандартад нийцсэн ISO 9001-2016 стандартын шаардлагыг хангасан ба түүнээс дээш чанартай байх
46	Лампир хүрээ /3м/		30	
47	Дүүжин тааз	м.кв	90	Монгол улсын MNS 3178-98 стандартад нийцсэн ба түүнээс дээш чанартай байх
48	Дүүжин таазны зам урт		30	
49	Дүүжин таазны зам богино		30	

50	Паркетан шал	м.кв	120	Зузаан, лакан өнгөлгөөтэй, давхар түгжээтэй, өнгө дизайны өргөн сонголттой, сайн чанартай, бат бөх, нягт сайтай байх. MNS 3027 : 1981 стандарт хангасан байх
51	Паркетан шал хүрээ	ш	60	Зузаан, өнгө дизайны өргөн сонголттой, сайн чанартай, бат бөх, нягт сайтай байх. MNS 3027 : 1981 стандарт хангасан байх
52	Паркетан шал булан	ш	30	
53	Паркетан шал залгаа	ш	30	
54	Паркетан шал төгсгөвч	ш	30	
55	Плита 30х20	ш	20	200 - /-70с/ хэмд тэсвэрэй давхар шаталттай бат бөх, даралт цохилтод тэсвэртэй, нягтрал сайтай ус бага шингээдэг, хир бага тогтдог, хальтирдаггүй гадаргуутай хүний биед сөрөг нөлөөгүй. MNS 0230 : 2004 стандарт хангасан байх.
56	Плита 30х60 хана	ш	20	
57	Плита 30х30 шал	ш	20	Төрөл бүрийн хэмжээтэй, төмөр сайтай удаан эдлэгээтэй байх. Монгол улсын стандартад нийцсэн ISO 9001-2016 стандартын шаардлагыг хангасан ба түүнээс дээш чанартай байх
58	Өрөм 6мм мод	ш	40	
59	Өрөм 8мм мод	ш	30	
60	Өрөм 10мм мод	ш	20	
61	Өрөм 12мм мод	ш	20	
62	Өрөм 14мм мод	ш	20	
63	Өрөм 6мм төмөр	ш	20	
64	Өрөм 7мм төмөр	ш	20	
65	Өрөм 10мм төмөр	ш	20	
66	Өрөм 12мм төмөр	ш	10	
67	Өрөм 14мм төмөр	ш	10	
68	Өрөм 16мм төмөр	ш	5	
69	Өрөм 18мм төмөр	ш	5	
70	Өрөм 6мм бетоны	ш	20	
71	Өрөм 8мм бетоны	ш	20	
72	Өрөм 10мм бетоны	ш	20	
73	Өрөм 12мм бетоны	ш	10	
74	Өрөм 14мм бетоны	ш	10	
75	Өрөм 16мм бетоны	ш	5	
76	Өрөм 18мм бетоны	ш	5	
77	Өрөмний ком	ш	10	
78	Нэмэх хошуу /дрилл/	ш	30	Төмөр сайтай, Монгол улсын стандартад нийцсэн ISO 9001-2016 стандартын шаардлагыг хангасан ба түүнээс дээш чанартай байх
79	Зуурагч хошуу /дрилл/	ш	1	
